



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА С.БЯМБАЦОГТ
ТАНАА

2025.09.23 № 43

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн
талаарх мэдээлэл ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2.3.7-д “хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.3.8-д “халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.” гэж, 2.1.3.10-т ““Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.” гэж, 2.1.3.17-д “улс төрийн амлалтаар өрх, иргэнд халамжийн нийтлэг мөнгөн шилжүүлэг олгохгүй байхаар нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг өөрчилнө.” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Нийгмийн халамжийн тухай хуульд зааснаар Монгол Улсын 0-18 насны хүүхэд бүрд мөнгөн тэтгэмж олгох, зохион байгуулах ажлыг Монгол Улсын Засгийн газар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хэрэгжүүлж буй хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох хөтөлбөр нь жишиг сайн хөтөлбөр болдог талаар олон улсын байгууллагын судалгаагаар дүгнэгдэж, хүүхэд бүрд мөнгөн тэтгэмжийг жигд олгож байгаа нь хүүхдийг ялгаварлан гадуурхагдах, гутаан доромжлуулахаас сэргийлэх, хүүхдийн эрх, нэр хүндэд халдахаас хамгаалж, тэгш байдлыг үүсгэх сайн талтай хэдий ч өнөөдрийн байдлаар нийт өрхийн 57.8 хувь нь хүүхдийн мөнгийг өргөн хэрэглээний бараа авахад зарцуулдаг талаар судалгаа гарсан байна.

Мөн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг зээл, өр төлбөрт суутгахыг, согтууруулах ундаа, тамхины хэрэглээнд зарцуулахыг хориглох талаар холбогдох хууль тогтоомжид заасан ч энэхүү зохицуулалт хэрэгжихгүй байна.

Иймд Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт дэвшүүлсэн “халамжаас хөдөлмөрт шилжих бодлого ...”-ын хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгохтой холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар дараах асуудалд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу дараах асуулгыг тавьж байна.

2025009073

1.Өрхийн амьжиргааны түвшинг нарийвчлан тооцсон тооцоолол /сүүлийн 4 жилийн байдлаар/, амьжиргааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээллийг;

2.Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зарцуулалтын талаарх судалгаа /2020-2025 оны байдлаар хэдэн хүүхдийн хэдэн хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан, тэдгээрийн хэд нь эцэг, эх, асран хамгаалагчийн нэр дээрх данстай холбосон, хэд нь хүүхдийн нэр дээр хадгаламж нээж дансанд байршуулсан/;

3.Хүүхдийн мөнгөний бодит хэмжээг инфляцтай уялдуулах эсэх талаар хийгдсэн судалгаа;

4.2022 оноос хойш хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулсан мөнгөн дүн, цаашид хүн амын өсөлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;


5.Хүүхдийн мөнгийг шууд хэрэглэж байгаа мөнгөний хэрэглээний судалгаа;

6."Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн талаар авах арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 71 дүгээр тогтоолын 2 дахь дэд заалтад "хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхдийн мөнгөн хуримтлал болон бусад хэлбэрээр хадгалах, хөрөнгө оруулалт хийх боломжийг олгох" гэж заажээ. Үүнтэй холбоотой хийгдэж буй ажлын талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.БАТ-ЭРДЭНЭ

2025000073